ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Өргөн сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДГА-2025/73/НА-СТА-ТШЗ**

Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Э.Эрдэнэсувд
Цахим хаяг: erdenesuvde@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг

2025 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2025.02.13 № 1-6/33

танай____________-ны №______________-т

ӨРГӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ТАМГЫН ДАРГА
О.ЦАСАНЦЭЦЭГ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өргөн сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Өргөн сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 14,073.7 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс 142,008.1 мянган төгрөгөөр их бөгөөд төсвийг зориулалт бусаар зарцуулсан, орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, зарцуулсан зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, 60 дугаар зүйлийн 60.2.9-д заасантай тус тус нийцээгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 82, 128 дугаар тогтоолын дагуу төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосон, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023.12.05-ны өдрийн 15/08 дугаар тогтоол, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023.12.15-ны өдрийн 14/06 дугаар тогтоолоор төрийн албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдлийг үндсэн цалингийн 40-100 хувиар олгосонтой холбоотой цалингийн сан нэмэгдсэн байна.

Тайлант онд иргэдийн Төлөөлөгчдийн 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 02/01 дугаар тогтоолоор 2024 оны төсвийг 230.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Нэмэгдүүлсэн төсвийг эдийн засгийн ангиллаар задалж үзвэл

1

010020006

тогтмол зардлыг 13.7 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 2.4 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 38.3 сая төгрөгөөр, нэг удаагийн буцалтгүй тусламж, шагнал урамшууллын зардлыг 3.0 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 200.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн, засаг даргын нөөц хөрөнгө, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлыг 26.9 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

**Аудитын гол асуудал**

Цалин хөлсийг илүү тооцож олгосон, Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг хэтрүүлэн зарцуулсан, өмнөх аудитаар илэрсэн төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллаагүй алдааг давтан гаргасан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 үндсэн зорилтын хүрээнд 173 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг сумын Засаг даргаас 90.3 хувиар үнэлжээ.

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **355,003,169.00** | **441,728,181.62** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 6,677,630.00 | 5,941,630.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 6,677,630.00 | 5,941,630.00 |
| **3121** | **Төгрөг** | 6,677,630.00 | 5,941,630.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 6,677,630.00 | 5,941,630.00 |
| **33** | **АВЛАГА** | 99,105,693.00 | 30,201,509.62 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 35,752.00 | 5,447,512.62 |
| **335** | **Бусад авлага** | 99,069,941.00 | 24,753,997.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 71,767,467.00 | 4,451,523.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 27,302,474.00 | 20,302,474.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 249,219,846.00 | 405,585,042.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 228,400.00 | 228,400.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 228,400.00 | 228,400.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 185,288,406.00 | 339,578,602.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,792,760.00 | 1,717,260.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 173,333,496.00 | 324,614,842.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 6,636,500.00 | 9,636,500.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 3,525,650.00 | 3,610,000.00 |
| 35600 | Мал амьтад | 63,703,040.00 | 65,778,040.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,413,474,359.65** | **2,825,047,410.25** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,413,474,359.65 | 2,825,047,410.25 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,012,118,775.92 | 2,429,023,410.25 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,324,693,542.00 | 1,364,593,542.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (174,534,189.12) | (214,715,228.04) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 615,121,325.00 | 658,304,525.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (356,094,094.28) | (348,991,754.60) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 158,303,215.60 | 261,438,841.60 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (93,517,791.50) | (105,245,465.54) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 45,308,085.00 | 74,248,085.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (33,975,161.34) | (39,419,806.67) |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 4,412.29 | 4,412.29 |
| 39212 | Хуримтлагдсан элэгдэл | (4,412.29) | (4,412.29) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,301,985,458.13 | 1,684,432,162.13 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (776,010,963.57) | (906,460,840.63) |
| 39217 | Ном | 839,350.00 | 839,350.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 401,355,583.73 | 396,024,000.00 |
| 39301 | Програм хангамж | 6,907,000.00 | 4,166,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (6,575,416.27) | (4,166,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 401,024,000.00 | 396,024,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,768,477,528.65** | **3,266,775,591.87** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **842,500.00** | **5,571,397.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 842,500.00 | 5,571,397.00 |
| **413** | **Өглөг** | 842,500.00 | 5,571,397.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 5,463,397.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 842,500.00 | - |
| **4136** | **Бусад өглөг** | - | 108,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 108,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,767,635,028.65** | **3,261,204,194.87** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,767,635,028.65 | 3,261,204,194.87 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 839,615,463.96 | 839,615,463.96 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,524,617,455.19 | 2,018,186,621.41 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,524,617,455.19 | 1,519,617,455.19 |

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 498,569,166.22 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 403,402,109.50 | 403,402,109.50 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,768,477,528.65** | **3,266,775,591.87** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,305,170,402.22** | **2,474,224,170.32** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **9,069,400.00** | **698,506,743.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 9,069,400.00 | 698,506,743.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 9,069,400.00 | 9,327,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,069,400.00 | 9,327,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | | 524,263,497.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | | 164,916,246.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,296,101,002.22** | **1,775,717,427.32** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 339,882,322.00 | 389,339,006.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 18,000,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 265,805,775.00 | 350,362,900.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 56,076,547.00 | 38,976,106.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 956,218,680.22 | 1,386,378,421.32 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 956,218,680.22 | 1,386,378,421.32 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,260,018,381.78** | **1,975,655,004.10** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,260,018,381.78** | **1,975,655,004.10** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,243,474,581.78 | 1,968,819,004.10 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 490,064,821.74 | 820,024,537.44 |
| 210101 | Үндсэн цалин | 259,542,602.11 | 370,489,447.98 |
| 210102 | Нэмэгдэл | 167,466,120.88 | 363,102,772.86 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 30,177,314.95 | 57,333,357.00 |
| 210104 | Урамшуулал | 32,878,783.80 | 29,098,959.60 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 60,593,889.06 | 103,037,327.12 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,305,398.96 | 71,587,936.26 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,906,336.56 | 8,434,700.38 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,933,868.42 | 6,457,516.47 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 858,928.48 | 1,703,141.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,589,356.64 | 14,854,032.58 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 55,641,357.37 | 63,126,521.68 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,001,718.37 | 17,098,701.68 |
| 210302 | Түлш, халаалт | 38,041,895.00 | 38,928,120.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,541,744.00 | 7,099,700.00 |
| 210304 | Байрны түрээс | 5,056,000.00 | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 138,204,610.00 | 59,495,140.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,475,700.00 | 2,798,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 39,632,865.00 | 44,534,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,997,870.00 | 3,629,890.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 647,500.00 | 346,750.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 88,450,675.00 | 8,186,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,857,505.53 | 16,595,050.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 275,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 210602 | Тавилга | 194,305.53 | - |
| 210604 | Урсгал засвар | 5,388,200.00 | 16,595,050.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,749,000.00 | 7,565,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,749,000.00 | 7,565,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 85,799,362.00 | 302,603,781.46 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 83,511,750.00 | 301,282,316.46 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 55,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,854,525.00 | 700,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 153,000.00 | 273,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 154,000.00 | 2,100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 71,087.00 | 345,465.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 397,564,036.08 | 596,371,646.40 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 187,130,095.00 | 341,710,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,529,500.00 | 1,553,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 207,904,441.08 | 253,107,346.40 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 16,543,800.00 | 6,836,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,543,800.00 | 6,836,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 5,340,100.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,203,700.00 | 6,836,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **45,152,020.44** | **498,569,166.22** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **45,152,020.44** | **498,569,166.22** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,317,296,901.22** | **1,838,185,894.32** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,985,900.00** | 10,351,000.00 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 5,985,900.00 | 10,351,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 5,985,900.00 | 10,351,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,985,900.00 | 8,351,000.00 |
| 1200047 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | | 2,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,311,311,001.22** | **1,827,834,894.32** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 355,092,321.00 | 441,456,473.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 18,000,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 265,805,775.00 | 350,362,900.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 71,286,546.00 | 91,093,573.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 956,218,680.22 | 1,386,378,421.32 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 956,218,680.22 | 1,386,378,421.32 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,161,997,471.22** | **1,707,504,994.32** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,161,997,471.22** | **1,707,504,994.32** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,093,336,204.22** | **1,697,901,971.32** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 490,115,906.79 | 821,865,937.70 |
| 210101 | Үндсэн цалин | 259,220,660.48 | 371,007,083.24 |
| 210102 | Нэмэгдэл | 167,839,147.56 | 363,241,665.86 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 30,177,314.95 | 57,217,229.00 |
| 210104 | Урамшуулал | 32,878,783.80 | 30,399,959.60 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 60,593,889.06 | 103,144,290.48 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,305,398.96 | 71,694,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,906,336.56 | 8,434,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,933,868.22 | 6,457,516.47 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 858,929.18 | 1,703,141.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,589,356.14 | 14,854,032.58 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 51,610,997.37 | 63,126,521.68 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,001,718.37 | 17,098,701.68 |
| 210302 | Түлш, халаалт | 38,041,895.00 | 38,928,120.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,731,384.00 | 7,099,700.00 |
| 210304 | Байрны түрээс | 836,000.00 | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 49,805,535.00 | 27,293,410.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,520,500.00 | 2,743,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 34,156,165.00 | 18,612,370.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,997,870.00 | 3,629,890.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,051,350.00 | 346,750.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,079,650.00 | 1,961,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 3,470,000.00 | 480,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,470,000.00 | 480,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 44,770,250.00 | 34,048,850.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 400,000.00 | 470,000.00 |
| 210602 | Тавилга | 31,280,000.00 | 7,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 13,090,250.00 | 26,578,850.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,749,000.00 | 7,565,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,749,000.00 | 7,565,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 100,119,072.00 | 270,794,161.46 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 97,831,460.00 | 269,472,696.46 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 55,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,854,525.00 | 700,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 153,000.00 | 273,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 154,000.00 | 2,100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 71,087.00 | 345,465.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 283,101,554.00 | 369,583,800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 280,572,054.00 | 368,030,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,529,500.00 | 1,553,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **68,661,267.00** | **9,603,023.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,543,800.00 | 6,935,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 5,340,100.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,203,700.00 | 6,935,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 52,117,467.00 | 2,668,023.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 52,117,467.00 | 2,668,023.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **155,299,430.00** | **130,680,900.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **159,271,800.00** | **131,416,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **159,271,800.00** | **131,416,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 159,271,800.00 | 131,416,900.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 159,271,800.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 131,416,900.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(159,271,800.00)** | **(131,416,900.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (3,972,370.00) | (736,000.00) |

| | | | |
|---|---|---|---|
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 6,677,630.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 6,677,630.00 | 5,941,630.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C 01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **839,615,463.96** | **403,402,109.50** | **1,524,617,455.19** | 2,767,635,028.65 |
| C 02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C 03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **839,615,463.96** | **403,402,109.50** | **1,524,617,455.19** | 2,767,635,028.65 |
| C 04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C 05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C 06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C 07 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| C 08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 839,615,463.96 | 403,402,109.50 | 1,524,617,455.19 | 2,767,635,028.65 |
| D 01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 839,615,463.96 | 403,402,109.50 | 1,524,617,455.19 | 2,767,635,028.65 |
| D 02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | (5,000,000.00) | (5,000,000.00) |
| D 03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **839,615,463.96** | **403,402,109.50** | **1,519,617,455.19** | **2,762,635,028.65** |
| D 04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D 05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D 06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D 07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D 08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 498,569,166.22 | 498,569,166.22 |
| D 09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **839,615,463.96** | **403,402,109.50** | **2,018,186,621.41** | 3,261,204,194.87 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Хэтрэлт хэмнэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,637,778,900.00 | 1,394,729,421.32 | 243,049,478.68 | 85.16 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,437,778,900.00 | 1,340,242,421.32 | 97,536,478.68 | 93.22 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,429,978,900.00 | 1,336,043,421.32 | 93,935,478.68 | 93.43 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 843,469,400.00 | 821,865,937.70 | 21,603,462.30 | 97.44 |
| 210101 | Үндсэн цалин | 367,376,400.00 | 371,007,083.24 | (3,630,683.24) | 100.99 |
| 210102 | Нэмэгдэл | 365,537,800.00 | 363,241,665.86 | 2,296,134.14 | 99.37 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 66,000,000.00 | 57,217,229.00 | 8,782,771.00 | 86.69 |
| 210104 | Урамшуулал | 44,555,200.00 | 30,399,959.60 | 14,155,240.40 | 68.23 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 105,433,700.00 | 103,144,290.48 | 2,289,409.52 | 97.83 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 71,694,900.00 | 71,694,900.00 | - | 100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,434,700.00 | 8,434,700.00 | - | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,747,800.00 | 6,457,516.47 | 290,283.53 | 95.70 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,686,900.00 | 1,703,141.43 | (16,241.43) | 100.96 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,869,400.00 | 14,854,032.58 | 2,015,367.42 | 88.05 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 70,261,300.00 | 63,126,521.68 | 7,134,778.32 | 89.85 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 16,992,700.00 | 17,098,701.68 | (106,001.68) | 100.62 |
| 210302 | Түлш, халаалт | 45,435,000.00 | 38,928,120.00 | 6,506,880.00 | 85.68 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,833,600.00 | 7,099,700.00 | 733,900.00 | 90.63 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 23,652,200.00 | 22,913,610.00 | 738,590.00 | 96.88 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,849,100.00 | 2,498,000.00 | 351,100.00 | 87.68 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,559,100.00 | 14,477,570.00 | 81,530.00 | 99.44 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,704,000.00 | 3,629,890.00 | 74,110.00 | 98.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 140,000.00 | 346,750.00 | (206,750.00) | 247.68 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,400,000.00 | 1,961,400.00 | 438,600.00 | 81.73 |
| **2105** | **Нормативт зардал** | 600,000.00 | 480,000.00 | 120,000.00 | 80.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 600,000.00 | 480,000.00 | 120,000.00 | 80.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 51,084,000.00 | 47,818,850.00 | 3,265,150.00 | 93.61 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,000,000.00 | 470,000.00 | 1,530,000.00 | 23.50 |
| 210602 | Тавилга | 19,600,000.00 | 20,770,000.00 | (1,170,000.00) | 105.97 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 29,484,000.00 | 26,578,850.00 | 2,905,150.00 | 90.15 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,772,200.00 | 6,665,000.00 | 107,200.00 | 98.42 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,772,200.00 | 6,665,000.00 | 107,200.00 | 98.42 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 320,506,100.00 | 262,975,811.46 | 57,530,288.54 | 82.05 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 318,899,700.00 | 261,654,346.46 | 57,245,353.54 | 82.05 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 700,000.00 | 700,000.00 | - | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 276,400.00 | 273,900.00 | 2,500.00 | 99.10 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 230,000.00 | 2,100.00 | 227,900.00 | 0.91 |
| 210807 | Газрын төлбөр | 400,000.00 | 345,465.00 | 54,535.00 | 86.37 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8,200,000.00 | 7,053,400.00 | 1,146,600.00 | 86.02 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,500,000.00 | 5,500,000.00 | - | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,700,000.00 | 1,553,400.00 | 1,146,600.00 | 57.53 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 7,800,000.00 | 4,199,000.00 | 3,601,000.00 | 53.83 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,800,000.00 | 4,199,000.00 | 3,601,000.00 | 53.83 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,800,000.00 | 4,199,000.00 | 3,601,000.00 | 53.83 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **200,000,000.00** | **54,487,000.00** | 145,513,000.00 | 27.24 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 200,000,000.00 | 54,487,000.00 | 145,513,000.00 | 27.24 |
| 221001 | Их засвар | 200,000,000.00 | 54,487,000.00 | 145,513,000.00 | 27.24 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,637,778,900.00 | 1,394,729,421.32 | 243,049,478.68 | 85.16 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,632,778,900.00 | 1,386,378,421.32 | 246,400,478.68 | 84.91 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,632,778,900.00 | 1,386,378,421.32 | 246,400,478.68 | 84.91 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 5,000,000.00 | 8,351,000.00 | (3,351,000.00) | 167.02 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,000,000.00 | 8,351,000.00 | (3,351,000.00) | 167.02 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **-** |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **441,456,473.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **441,456,473.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | **438,788,450.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | **4,379,800.00** |
| 210401 | Бичиг хэрэг | - | 245,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 4,134,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 900,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 900,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | **70,978,250.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 70,978,250.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 362,530,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 362,530,400.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **2,668,023.00** |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 2,668,023.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | **441,456,473.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | **441,456,473.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 350,362,900.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 91,093,573.00 |

## 2.6 Аудит хийсэн ахмадын сангийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **2,736,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **2,736,000.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **-** | **2,736,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **-** | **2,736,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 2,736,000.00 |
| **1** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** | **2,000,000.00** |
| **35** | **ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **-** | **2,000,000.00** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 2,000,000.00 |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **6,677,630.00** |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **5,941,630.00** |

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 226,106.5 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчил илэрснээс 70,024.8 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад бүрэн залруулсан.

### 3.1. Залруулсан алдаа

1. Тайлант хугацааны нийгмийн даатгалын шимтгэл, татварын өглөг авлага 3,824.1 мянган төгрөгийг данс бүртгэлд тусгаагүй,

2. Тайлант хугацаанд урьдчилж төлсөн зардал 7,000.0 мянган төгрөгийг өглөг, авлагын дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн, 9,400.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа, 44.0 мянган төгрөгийн бичиг хэргийн зардлыг алдаатай бүртгэсэн, малын нас дэвшилтийг 3,890.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,

3. Тайлант хугацаанд худалдан авсан, хандив тусламжаар ирсэн өвс, тэжээлийн зарцуулалт 39,980.0 мянган төгрөгийн зарцуулалтыг бараа материалын тайланд бүрэн, үнэн зөв тайлагнаагүй,

4. Үндсэн хөрөнгийн 796.7 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тооцсон, эцсийн үлдэгдлийг 5,000.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн,

5.Тайлант хугацааны төрийн сангийн дансны үлдэгдлийг 90.0 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн зөрчил тус тус илэрлээ.

Аудитаар нийт 156,081.8 мянган төгрөгийн 4 зөрчил илэрсэнд 3,855.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 152,225.8 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 156,081.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 142,008.1 мянган төгрөгөөр их тул  Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

### 3.2. Төлбөрийн акт

1. Цалин хөлс тооцоолон олгохдоо 1 албан хаагчид 915.5 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон,

2. Нийт 6 албан хаагчид 2,940.4 мянган төгрөгийн цалинг давхардуулан олгосон байна.

### 3.3. Албан шаардлага

1. Тайлант хугацааны урсгал засварын зардлын батлагдсан төсөв 29,484.0 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлээр 26,578.8 мянган төгрөгийн урсгал засварын материал худалдан авсан боловч худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

2. Байгууллагын батлагдсан Их засварын зардлаас 102,647.0 мянган төгрөгийн 2 автомашин худалдан авч хөрөнгө бэлтгэн зардлыг зориулалт бусаар зарцуулсан, Засгийн газрын 2020.10.20 өдрийн 271 дүгээр тогтоолоор Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг суманд 5,000.0 мянган төгрөг байхаар тогтоосон байхад сумын баяр наадмын үйл ажиллагаанд нийт 10,000.0 мянган төгрөг зарцуулж, төсвийг 5,000.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

3. Төсвийн тухай хуулийн 60.2.9-д заасан Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив 18,000.0 мянган төгрөгийг байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, зарцуулсан байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | Зөвлөмж | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залру... | Залруулсан | | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Өглөг, авлагыг санхүүгийн тайланд бүрэн тусгаагүй | 1 | 3,824.1 | 1 | 3,824.1 | | | 1 | 3,824.1 | | | | |
| Орлого үр дүнгийн тайланг алдаатай илэрхийлсэн | 1 | 20,334.0 | 1 | 20,334.0 | | | 1 | 20,334.0 | | | | |
| Бараа материалын тайланг үнэн зөв тайлагнаагүй | 1 | 39,980.0 | | | 1 | 39,980.0 | 1 | 39,980.0 | | | | |
| Үндсэн хөрөнгийн тайланг алдаатай илэрхийлсэн | 1 | 5,796.7 | | | 1 | 5,796.7 | 1 | 5,796.7 | | | | |
| Төрийн сангийн дансны үлдэгдлийг илүү тусгасан | 1 | 90.0 | | | 1 | 90.0 | 1 | 90.0 | | | | |
| **Дүн** | **5** | **70,024.8** | **2** | **24,158.1** | **3** | **45,866.7** | **5** | **70,024.8** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтн | Тоо | Дүн |
| Төсвийг зориулалт бусаар зарцуулсан | 1 | 107,647.0 | | | 1 | 107,647.0 | | | | | | |
| Албан хаагчдад цалин хөлсийг илүү тооцож олгосон | 1 | 915.5 | 1 | 915.5 | | | | | | | | |
| Албан хаагчдад цалин хөлсийг илүү тооцож олгосон | 1 | 2,940.4 | 1 | 2,940.4 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй | 1 | 26,578.9 | | | | | | | 1 | 26,578.9 | | |
| Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх орлогыг байгууллагын нэмэлт дансанд төвлөрүүлж, зарцуулсан | 1 | 18,000.0 | | | 1 | 18,000.0 | | | | | | |
| **Дүн** | **5** | **156,081.8** | **2** | **3,855.9** | **2** | **125,647.0** | **-** | **-** | **1** | **26,578.9** | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | - |
| **Дүн** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Нийт дүн | - | - | - | - | - | - | - | - |

### ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | Аудитад хамрагдах | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | | 1 | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | | **1** | | |